Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Дээд боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, ахлах мэргэжилтэн, Жигжид Солонго

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх | | | | | | | |
| 1 | Боловсролын сайдын 2024 оны А/64 тоот “Багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох үйл ажиллагааны журам”-ын хүрээнд 45 хоногийн сургалтын хэрэгжилтийг хангаж ажиллах | Шинээр бэлтгэгдсэн багшийн тоо, ажлын байранд гарсан судалгаа | Хамтран ажиллаж буй их, дээд сургууль -6, суралцагчийн тоо 73 | Багшлах эрх олгох 45 хоногийн сургалтад хамрагдсан иргэдийг мэдээллийн санд бүртгэж, 100% гэрчилгээ олгосон байна. | Их засаг их сургууль 2025.02.15-ны өдрөөс сургалтын "Багшлах эрхийн гэрчилгээ олгох" сургалтын үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд тус сургууль нь Мэдээлэл зүй, Гадаад хэл шинжлэлийн чиглэлээр Хүмүүнлэгийн ухааны тэнхим хариуцаж сургалтыг явуулж байна. Нийт 150 гаруй хүн бүртгүүлснээс шаардлага хангасан 40 гаруй хүний материалыг бүрдүүлэн БЕГ-т илгээсэн. Үүнээс мөн БАБ, СӨБ хөтөлбөрийн 12 суралцагч хасагдсан бөгөөд одоогийн байдлаар 25 хүн суралцаж байна. Үүний 14 мэдээлэл зүйгээр, 11 гадаад хэл шинжлэлээр суралцсан. 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр нийт 24 иргэн "Багшлах эрхийн гэрчилгээ"-г гардан авсан, ОУУБИС нь “Багшлах эрхийн гэрчилгээ олгох” сургалтыг 2024 оны 12 сард 1-р ээлжийн сургалтыг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | амжилттай зохион байгуулан 25 хүнийг төгсгөсөн. Иймд сургуулийн зүгээс дахин сургалт явуулах зарыг өөрийн сургуулийн веб хуудас болон зөвлөх багшийн веб хуудсаар олонд түгээн багшлах хүсэлтэй иргэдийн тоо бүрдсэнээр 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс 2-р ээлжийн сургалтыг зохион байгуулсан байна. Сургалтад суралцах хүсэлтээ илэрхийлж нийт 98 хүн бүртгүүлснээс шаардлага хангасан 50 хүнийг бүртгэн 46 иргэн амжилттай төгссөн. 2025 оны 5 дугаар сарын 5-ны өдрөөс МУБИС 2 дугаар ээлжийн сургалтаа 35 суралцагчтайгаар эхлүүлсэн, СЭЗИС 6 дугаар сарын 5-ны өдрөөс 2 дугаар ээлжийн сургалт эхлэхээр бүртгэлийн үйл ажиллагаа эхэлсэн явагдаж байна. 2024 оны 11 сараас 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдөр хүртэлх хугацааны "Багшлах эрхийн гэрчилгээ олгох" сургалтад 1 дүгээр ээлжийн сургалтад хамрагдсан 129 иргэнээс 69 иргэнтэй холбогдож асуумж судалгаа авч үр дүнгийн тайлан гаргасан. Нийт төгсгөгчдөөс 68 иргэн багшаар ажиллаж, 21 иргэн өөрийн одоогийн ажлаа хийж байна, 2 иргэн одоогоор ажиллах боломжгүй, 36 иргэн ЕБС-д ажиллах хүсэлтэй ажил хайж байна. Үүнээс 28 иргэн орон нутагт, 40 иргэн нийслэлд ажиллаж байна. https://forms.gle/bbeePRrKwUbg1cni7<br>Хавсралт: 8 файл | | |
| 2 | Их, дээд сургуулийн | Сургалт, үйл ажиллагааны | Сургалт, хэлэлцүүлэг- | Багш бэлтгэдэг их дээд | ДБСБ-ын “Багшийн хөгжлийн төв” -үүдийг хариуцсан багш ажилтнуудыг | 1-р сар, 2-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах | батлагдсан хөтөлбөр, удирдамж, оролцогчдын тоо, эзлэх хувь | 3, Оролцогч-500 | сургуулийн багшийн хөгжлийг дэмжих цахим сургалтын төлөвлөгөө, удирдамж, хөтөлбөр боловсруулж, сургалтад нийт багш нарын 50 хувийг хамруулж, тайлан гаргасан байна. | чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг Багшийн хөгжлийг дэмжих хуулийн хэрэгжилтийг хангах, дээд боловсролын сургалтын байгууллагын “Багшийн хөгжлийн төв”-ийн багш ажилтнуудын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, харилцан туршлага солилцохоор Боловсролын Ерөнхий газар, Отгонтэнгэр их сургууль хамтран сургалт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 28 өдөр зохион байгуулсан. Боловсролын ерөнхий газрын Дээд боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, ахлах мэргэжилтэн Ж.Солонго БЕГ-аас багшийн хөгжил, багшийн хөгжлийн төвүүдийг дэмжих чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаа, бодлогыг танилцуулсан. Сургалтад МУИС, ХААИС, ҮБХИС, ДХИС, ОТИС, СЭЗИС, Шихихутуг, Мандах, Батлан хамгаалахын их сургууль, Технологийн дээд сургууль, Урлах эрдмийн дээд сургууль зэрэг улсын болон хувийн дээд боловсролын байгууллагуудын 51 багш судлаач оролцлоо. Сургалт, хэлэлцүүлгийн үеэр Багшийн хөгжлийн төвүүдийн хамтын ажиллагаа, харилцан түншлэлийг хөгжүүлэх санал санаачилга гаргаж, сайн дурын нэгдсэн сүлжээ байгуулахаар болсон. Дээд боловсролын сургалтын байгууллагын "Багшийн хөгжлийн төв"-ийг хариуцан ажиллаж байгаа мэргэжилтэн, багш, ажилтан, менежер нарын нийт 28 хүний цахим уулзалтыг 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдөр | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулсан. Тус уулзалтаар дээд боловсролын байгууллагын "Багшийн хөгжлийн төв"-ийн багш, ажилтнуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сургалтыг улирлаар сэлгэн явуулах тухай ярилцаж дараагийн сургалтыг ХААИС-ийн "Багшийн хөгжлийн төв"-ийн багш, ажилтан нартай хамтран 2025 оны 10 дугаар сард багтаан зохион байгуулахаар болсон. Энэ сургалтыг улиралд 1 удаа тогтмол зохион байгуулах зорилготой ажиллаж байна.<br>Хавсралт: 4 файл | | |
| 3 | Сургалтын байгууллагын багш, ажилтнуудыг чадавхжуулах сургалтаас бусад олон талт үйл ажиллагааг (онол практикийн хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, судалгаа, төсөлт хөтөлбөр, хамтын ажиллагааны туршлага судлах) зохион байгуулах | Зохион байгуулсан болон хамтран ажилласан үйл ажиллгааны тоо, төсөл | - | 100% үйл ажиллагааны удирдамж, хөтөлбөр, төлөвлөлт боловсруулсан байх | “Англи Хэл Мэргэшлийн Төв”-ийн үйл ажиллагаа, төлөвлөгөөг танилцуулах, цаашид урт удаан хугацаанд хамтран ажиллаж болох санал санаачилгыг ярилцах зорилгоор оролцогч талуудын анхны Дугуй ширээний уулзалтад оролцсон. Тус уулзалтад Боловсролын яам, Монгол Улсын Их Сургууль, Боловсролын Ерөнхий Газар, Улаанбаатар дахь Австрали, Их Британи, болон Канадын элчин сайдын яамд бусад холбогдох байгууллагуудын төлөөлөл оролцсон. Уулзалтаар орон даяар Англи хэлний боловсролыг цаашид бэхжүүлэх олон талт хамтын ажиллагааны боломжуудын талаар харилцан санал солилцсон. Уулзалт 2025 оны 4-р сарын 16 (Лхагва гараг)-т 14:00 – 16:30 хооронд МУИС-ийн номын санд явагдсан. 2025 оны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад ерөнхий боловсролын сургуулийн багш нарт | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн үзэл баримтлал, онцлог арга зүйг таниулах, эргэцүүлэлд суурилсан багшлахуй ба хичээлийн судалгааны арга зүй, сургалтын цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх мэдлэг, ур чадварыг дэмжих сургалтын сургагч багшаар 4 дүгээр сарын 1-нд Архангай аймагт Н.Болорцэцэг, С.Долгормаа, Г.Хүрэлбаатар нарын хамт, 4 дүгээр сарын 8-9-ний өдрүүдэд нийслэлийн Баянзүрх дүүргийн 97 дугаар сургууль дээр Н.Болорцэцэг, Ц.Нарантуяа, Д.Нямсүрэн, Г.Хүрэлбаатар, 4 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд нийслэлийг Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй ахлах сургууль дээр Д.Энхтулга, Ц.Нарантуяа, Ж.Ууганцэцэг, Н.Насантогтох нарын хамт МДҮС-ын сургагч багшаар ажилласан.4 дүгээр сарын 8-ны өдөр Сонгинохайрхан дүүрэгт МДҮС-ын бэлтгэл ажлыг хангаж ажилласан. 4 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зөвлөх багш нарын гэрээг боловсруулах, батламжийн эх бэлтгэх ажил хийгдсэн.<br>Хавсралт: 5 файл | | |
| 4 | Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийг хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх модуль сургалт зохион байгуулах | Сургалтад хамрагдсан багшийн тоо | - | - | ДБСБ-ын “Багшийн хөгжлийн төв” - үүдийг хариуцсан багш ажилтнуудыг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг Багшийн хөгжлийг дэмжих хуулийн хэрэгжилтийг хангах, дээд боловсролын сургалтын байгууллагын “Багшийн хөгжлийн төв”-ийн багш ажилтнуудын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, харилцан туршлага солилцохоор Боловсролын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ерөнхий газар, Отгонтэнгэр их сургууль хамтран сургалт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 28 өдөр зохион байгуулсан. Боловсролын ерөнхий газрын Дээд боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, ахлах мэргэжилтэн Ж.Солонго БЕГ-аас багшийн хөгжил, багшийн хөгжлийн төвүүдийг дэмжих чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаа, бодлогыг танилцуулсан. Сургалтад МУИС, ХААИС, ҮБХИС, ДХИС, ОТИС, СЭЗИС, Шихихутуг, Мандах, Батлан хамгаалахын их сургууль, Технологийн дээд сургууль, Урлах эрдмийн дээд сургууль зэрэг улсын болон хувийн дээд боловсролын байгууллагуудын 51 багш судлаач оролцлоо. Сургалт, хэлэлцүүлгийн үеэр Багшийн хөгжлийн төвүүдийн хамтын ажиллагаа, харилцан түншлэлийг хөгжүүлэх санал санаачилга гаргаж, сайн дурын нэгдсэн сүлжээ байгуулан ажиллана.<br>Хавсралт: 2 файл | 11-р сар, 12-р сар | |
| 5 | Төрөлжсөн ахлах сургууль, их, дээд сургуулийн байгалийн ухааны хичээлийг англи хэлээр заах боломжийг бүрдүүлэх | Төрийн өмчийн их сургуулийн англи хэл дээр заах хичээлийн эзлэх хувь | - | Англи хэл дээр сургалт явуулах чадвартай багшийн тоон судалгааг 100% гаргах | 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдөр ERASMUS+ RETEACH буюу "МОНГОЛ УЛСЫН БАГШ БЭЛТГЭХ БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙГ НОГООН БОЛОН ДИЖИТАЛ ШИЛЖИЛТЭД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧЛЭХ" ТӨСӨЛ-ийн хүрээнд Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Отгонтэнгэр Их Сургууль, Румыны Брасов дахь Трансилваний Их Сургууль, Италийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Палермогийн их сургууль, Боловсролын хамтын ажиллагааны байгууллага CESIE, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, МУИС-ийн Зүүн Бүсийн Сургууль, Хангай Дээд Сургууль, Дархан Дээд Сургууль зэрэг гадаад, дотоодын их сургуулиуд, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хамтран оролцсон хурал хэлэлцүүлэг болсон. Энэхүү төсөл нь европын багшийн боловсролын бодлого, сургалтын шинэ аргачлалаас суралцаж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн шилдэг туршлагыг Монгол Улсад нутагшуулах зорилготой. Тус хурал хэлэлцүүлэгт БЕГ-аас Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын дарга Б.Лхагвабаяр, Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн А.Цэнгүүнжаргал нарын хамтаар оролцсон. “Англи Хэл Мэргэшлийн Төв”-ийн үйл ажиллагаа, төлөвлөгөөг танилцуулах, цаашид урт удаан хугацаанд хамтран ажиллаж болох санал санаачилгыг ярилцах зорилгоор оролцогч талуудын анхны Дугуй ширээний уулзалтад оролцсон. Тус уулзалтад Боловсролын яам, Монгол Улсын Их Сургууль, Боловсролын Ерөнхий Газар, Улаанбаатар дахь Австрали, Их Британи, болон Канадын элчин сайдын яамд бусад холбогдох байгууллагуудын төлөөлөл оролцсон. Уулзалтаар орон даяар Англи хэлний боловсролыг цаашид бэхжүүлэх олон талт хамтын ажиллагааны боломжуудын талаар харилцан санал | 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | солилцсон. Уулзалт 2025 оны 4-р сарын 16-ны өдөр зохион байгуулагдсан.<br>Хавсралт: 8 файл | | |
| 6 | СӨБ, ЕБС болон их дээд сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтаас бусад олон талт (эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал, зөвлөгөөн, төсөл, хэлэлцүүлэг, түншлэл, хамтын үйл ажиллагаа) ажлыг зохион байгуулах. | Сургалт, үйл ажиллагааны батлагдсан хөтөлбөр, удирдамж, тайлан, оролцогчдын тоо биелэлтийн хувь | Сургалт, үйл ажиллагаа-6, оролцогч-1140 | 100 | 2025.02.12-2025.02.14-ний өдрүүдэд нийслэлийн ЕБС-ийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн танхимын сургалт зохион байгуулсан. Нийт 155 сургалтын менежер хамрагдсан. 2025 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс 2025 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хооронд Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулдаг Сургалтын байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр Сургалтын байгууллагын орчны аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Төмөр-Очир, Байгалийн ухааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан арга зүйч, мэргэжилтэн Л.Алтанчимэг, Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн Батзаяа, 147-р сургуулийн сургалтын менежер Сарантуяа, 48-р сургуулийн сургалтын менежер Пүрэвсүрэн нарын хамт Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын сургуулиуд дээр комиссоор ажилласан.<br>Хавсралт: 4 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах | | | | | | | |
| 7 | Авлигын эсрэг хууль, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг | Биелэлт /хувь/ | 100 | 100% хэрэгжүүлж ажиллах | Авлигын эсрэг хууль, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх | | | | үүргийг хэрэгжүүлэн ажилласан. | 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 8 | Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулах | Биелэлт /хувь/ | - | 50% | Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгосон. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 9 | Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах | Хэрэгжилт /хувь/ | - | 100% | 2025.04.21-ний өдөр, 2025.05.05-ны өдрийн "Мэдээлэл солилцох уулзалт"-ын хөтөлбөрийг боловсруулан уулзалтын ирц бүртгэх, чиглүүлэх ажил үүргийг гүйцэтгэсэн<br>Хавсралт: 2 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо, баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж албан тушаалтанд хүргүүлэх | Хугацаанд нь биелүүлсэн ажил, боловсруулсан баримт бичгийн тоо | 100% | 100% | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг цаг тухайд биелүүлсэн. А/64 тоот тушаалийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо, баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж албан тушаалтанд хүргүүлсэн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 11 | Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцах эрхтэй холбоотой үүссэн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авах, шийдвэрлэх | Биелэлтийн хувь | - | 100% | Санал, гомдол гарсан асуудалгүй. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албаны чадваржуулах богино хугацааны сургалтад хамрагдах | Төрийн албаны чадваржуулах богино хугацааны сургалтад хамрагдах | - | 1 сургалтад хамрагдах | 2025.02,.05-2025.02.07- ны өдрүүдэд "MOZAIK education" ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ЦАХИМ КОНТЕНТ, ДИЖИТАЛ СУРАХ БИЧГИЙН ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан. Хавсралт: 1 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Монгол бичгийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх сургалт хамрагдах | Монгол бичгийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн сургалтад хамрагдан батламж сертификат авах | - | 2 сургалтад хамрагдан батламж сертификат авах | Монгол бичгийн ахисан шатны цахим хичээлийн 3-р шатны сургалтад хамрагдсан. "Жендрийн мэдрэмжтэй харилцаа холбоо" сургалтын 1-р шатны сургалтад хамрагдсан. Хавсралт: 1 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Дээд боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, ахлах мэргэжилтэн, Жигжид Солонго /................................................./
Огноо: .........................